



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

“Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн
хариуцсан комисс”-ын бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1.7 дахь заалт, “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Өмчийн харилцааны газрын “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, даргын зөвлөлийн хуралд тайлагнахыг комиссын дарга (Н.Хашцэцэг)-д үүрэг болгосугай.


3.Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны А/171 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 03 өдрийн
А/15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан
комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

Өмчийн бүртгэл, мэдээллийн
хэлтсийн дарга

Гишүүд:

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн
хэлтсийн дарга

Өмчийн менежментийн хэлтсийн
дарга

Өмчийн хяналт, ашиглалт, дотоод
аудитын хэлтсийн дарга

Хөрөнгө хариуцсан ахлах зохион
байгуулагч

Нарийн бичгийн дарга:

Өмчийн бүртгэл, мэдээллийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны .03. дугаар сарын .03. өдрийн
А/15 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН “ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН ХАРИУЦСАН КОМИСС”-ЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс” (цаашид “комисс” гэх) нь нийслэлийн Өмчийн харилцааны газрын дэргэд ажиллах бөгөөд комиссын үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Комисс нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, нийслэлийн Засаг даргаас гаргасан өмч хөрөнгийн холбогдолтой эрх зүйн актуудыг мөрдлөг болгоно.

1.3.Комиссын гаргасан шийдвэрийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталгаажуулна.

Хоёр.Комиссын бүтэц, ажлын зохион байгуулалт

2.1.Комиссын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах чиг үүрэг бүхий тодорхой албан тушаалтнуудыг оролцуулан комиссыг газрын даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байхаар байгуулна.

2.2.Комиссын даргаар өмчийн бүртгэл мэдээллийн хэлтсийн дарга, гишүүдэд бусад хэлтсийн дарга нар, комиссын нарийн бичгийн дарга нь Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн байна.

2.3.Комиссын гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд комиссын даргад мэдэгдэх ба түүнийг тухайн нэгжийн ахлах мэргэжилтэн орлоно.

2.4.Хурал нь нийт гишүүдийн 50-иас дээш хувь нь биечлэн оролцсоноор хүчинтэйд тооцогдоно.

2.5.Хурлыг 14 хоног тутам лхагва гарагт зохион байгуулах ба комиссын дарга хурал товлож, нарийн бичгийн даргаар дамжуулан бусад гишүүдэд зарлана.

2.6.Комиссын хурлаар оруулах асуудлуудыг тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст хянуулж, хурал товлогдсон өдрөөс 1 хоногийн өмнө хурлын нарийн бичигт ирүүлнэ.

2.7.Үндсэн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдох материалыг хариуцсан мэргэжилтэн комиссын хуралд танилцуулан асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

Гурав.Комиссын эрх, үүрэг

3.1.Комисс дараах эрхтэй.

3.1.1.шаардлагатай тохиолдолд комисс тухайн байгууллага дээр очиж өмч хөрөнгийн байдалтай танилцаж, шийдвэр гаргана;

3.1.2.данснаас хасах шийдвэр гарч, шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байлгах асуудлыг хуулийн этгээдийн удирдлага хариуцаж, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээх бөгөөд эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан, өмч хөрөнгийг үрэгдүүлсэн бол хариуцлага тооцох саналыг комисс боловсруулж, Даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлнэ.

3.2.Комисс дараах үүрэгтэй.

3.2.1.комисс нь үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын хурлыг шударга, ил тод хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ;

3.2.2.комисс нь Газрын даргад үйл ажиллагаагаа тайлагнана.

3.3. Комиссын дарга дараах эрх, үүрэгтэй.

3.3.1.комиссын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг баталж, хуралдааныг даргалах;

3.3.2.үндсэн хөрөнгийн хөдөлгөөний асуудлаар комиссын нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтийг тооцох;

3.3.3.комиссын хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах;

3.3.4.комиссын дарга шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно;

3.3.5.комиссын дарга эзгүй тохиолдолд түүний санал болгосон комиссын гишүүн хурлыг удирдана.

3.4.Комиссын нарийн бичгийн дарга дараах эрх, үүрэгтэй.

3.4.1.мэргэжилтний нэгжийн даргаар баталгаажуулсан хурлаар оруулах асуудлуудын төлөвлөгөөг боловсруулан комиссын даргаар батлуулна;

3.4.2.комиссын хуралдааны тэмдэглэлийг шийдвэрийн төслийн хамт Газрын даргад танилцуулж, гарсан шийдвэрийг баталгаажуулсны дараа газрын цахим хуудсанд нээлттэй мэдээлнэ;

3.4.3.комиссын нарийн бичгийн дарга нь эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ хувийн ашиг сонирхлын үүднээс хандах, бусад гишүүдэд нөлөөлөхийг хориглоно.

3.5.Комиссын гишүүн дараах эрх, үүрэгтэй.

3.5.1.комиссын гишүүн нь хуралдаанд таслах эрхтэй оролцоно;

3.5.2.комиссын гишүүн нь шийдвэр гаргахдаа хувийн ашиг сонирхлын үүднээс асуудалд хандах, бусад гишүүдэд нөлөөлөхийг хориглоно.

Дөрөв.Хурлын шийдвэр, хяналт

4.1.Комиссын хуралдааны шийдвэрийг газрын дарга хянаж баталгаажуулна.

4.2.Комиссын хуралдааны шийдвэрийн биелэлтэд нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс хяналт тавьж ажиллана.

4.3.Хуралдаанд асуудал оруулж, шийдвэрлүүлсэн мэргэжилтэн өмч, хөрөнгийн хөдлөл, өөрчлөлттэй холбоотой шийдвэрийн биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

Данснаас хасах эд хөрөнгийг үзэж,
танилцсан тэмдэглэл

... оны ... сарын ... –ний өдөр

№

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчит төсөвт байгууллага, үйлдвэрийн газар
 –ын 20 ... оны ... сарын ... –ны
 өдрийн дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу акталж, данснаас хасах нийт
 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эд хөрөнгийг газар дээр нь нэг бүрчлэн үзэж
 танилцлаа. Үзэж танилцахад
 Дарга (захирал, эрхлэгч)
 Нягтлан бодогч
 Нярав
 Өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөөлөгч
 НӨХГ-ын хэлтсийн мэргэжилтэн
 НӨХГ-ын менежер
 НӨХГ-ын нярав
 нар оролцов.

Данснаас хасах эд хөрөнгийн байдлыг үзэж танилцаад дараах дүгнэлтийг гаргав.

Үүнд:

- Худалдан борлуулах хөрөнгө
- Татан төвлөрүүлэх хөрөнгө
- Устгах хөрөнгө
- (тоо ширхэг, бүртгэлийн үнэ тавих)

Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс дээрх хөрөнгийг худалдах,
 шилжүүлэх, акт тогтоон устгах талаар гаргасан санал дүгнэлт хуудас, тоног
 төхөөрөмжийн эвдрэл гэмтлийн талаарх мэргэжлийн байгууллагын техникийн дүгнэлт
 хуудас, тодорхой этгээдийн буруутай үйл ажиллагаанаас болж эд хөрөнгө нь
 ашиглалтын хугацаанаас өмнө эвдэрч гэмтсэн бол холбогдох бичиг баримт хуудас,
 нийт хуудас бичиг баримт байна.

Данснаас хасах эд хөрөнгийн тухай асуудлыг “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан
 комисс”-ын хурлаар хэлэлцүүлж, нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 тушаалаар шийдвэрлэх тул шийдвэр гарч, хэрэгжих хүртэл хугацаанд иж бүрдэл, чанар,
 бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй хэвээр байлгахыг

нарт хариуцуулав. Хариуцлага алдвал хууль тогтоомжийн дагуу учруулсан хохирлыг
ТБОНӨТХ-ийн дагуу төлүүлэх болно гэдгийг мэдэгдэв.

Эд хөрөнгийг үзэж танилцсан:

- НӨХГ-ын хэлтсийн мэргэжилтэн
- НӨХГ-ын менежер
- НӨХГ-ын нярав

Эд хөрөнгийг танилцуулж, бүрэн бүтэн байдлыг хариуцсан:

- Дарга.....
- Нягтлан бодогч Утас:
- Нярав Утас:
- ӨХБЗ-ийн төлөөлөгч Утас:

